

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ 9 ДҮГЭЭР ХУРАЛДААН**

Хуралдаан 2018 оны долоодугаар сарын 6-ны өдрийн 9 цаг 20 минутад эхэлж, 11 цаг 48 минут хүртэл Засаг даргын Тамгын газрын даргын өрөөнд болж, нийт 2 цаг 28 минут үргэлжлэв.

№	Хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	Шийдвэр
1	Сайхан-Овоо сумын сургуулийн захирал, Гурвансайхан, Өлзийт, Луус сумын цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнгийн тухай.	Өлзийт сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн Ц.Наранбаатар өөрийн биеэр ирж хуралд оролцоогүй тул хойшлуулав.
2	Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын Мал эмнэлэг, үржлийн тасгийн дарга, Сайнцагаан, Дэрэн, Дэлгэрцогт сумын Эрүүл мэндийн төвийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнгийн тухай.	Дэлгэрцогт сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Даваа овогтой Лувсандавга 67,9 оноогоор, Дэрэн сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Бямбасүрэн овогтой Ганбаатар 74,1 оноогоор тус тус тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлэхээр шийдвэрлэв.
3	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх тухай -Нөөцийн зараар бүртгүүлсэн иргэдийг тухайн албан тушаалд нь нэр дэвшүүлэх -Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэргэжилтэн, Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалд нөөцөөс нэр дэвшүүлэх	Дундговь аймаг дахь Шүүхийн Тамгын газрын Шүүх хуралдааны нарийн бичгийн даргын албан тушаалд Батсуурийн Даваасүхийг, Нийгмийн даатгалын хэлтсийн Санхүү, бүртгэлийн тасгийн Эрүүл мэндийн даатгалын орлого, шимтгэл хариуцсан байцаагчийн албан тушаалд Ганчимэгийн Осоржамааг, Нийгмийн даатгалын хэлтсийн Хулд сумын нийгмийн даатгалын байцаагчийн албан тушаалд Баттогтохын Номуундарийг, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Гурвансайхан сум хариуцсан газрын даамлын албан тушаалд Дагмидын Цэрэннадмидыг, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Цагаандэлгэр сум хариуцсан газрын даамлын албан тушаалд Буянтогтохын Түвшинтөгсийг, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалд Цэдэнбатын Энхтуяаг, Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалд Цэрэндашийн Ууганнасандоржийг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мэргэжилтний албан тушаалд Эрдэнэтогтохын Одонтуяаг тус тус нэр дэвшүүлж, шалгалтын материалыг холбогдох байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэв.
4	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцийн зард зарлуулах тухай	Дундговь аймгийн нутгийн захиргааны байгууллагуудын захиалгын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын дэс түшмэлийн 3 туслах түшмэлийн 7 нийт 10 сул орон тоог нөөцийн зард зарлуулахаар шийдвэрлэж, ТАЗ-д хүргүүлэхээр болов.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ